Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ГАЗАР

“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

2025.12.19

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх		1	1	100%
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	1	100%
3		Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0,5	0,5	100%
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0,5	0,5	100%
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0,5	0,5	100%
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0,5	0,5	100%
Хэсгийн оноо				**4**	4	100%
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх		1	1	100%
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	0	0%

6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал	1	1	100%
Хэсгийн оноо			**3**	2	66,6%
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал	1	1	100%
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал	1	1	100%
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал	1	1	100%
Хэсгийн оноо			**3**	3	100%
Нийт оноо			**10**	10	88.8%

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ГАЗАР

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга
Ургамал хамгааллын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Ёс зүйн дэд хороо байгуулах тухай” А/38 дугаар тушаалаар Ургамал хамгааллын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдан ажиллаж байна. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний даргаар Ургамлын хорио цээр, экспорт, импортын хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Батзориг, Нарийн бичиг Архив, бичиг хэргийн ажилтан Э.Номин-Эрдэнэ, гишүүн Ургамлын хортон шавжийн асуудал хариуцсан мэргэжилтэн И.Дагиймаа нар тус тус томилогдсон. Ургамал хамгааллын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “Ёс зүйн дэд хороо шэнэчлэн байгуулах тухай” А/90 дугаар тушаалаар шинэчлэгдэж, Бэлчээр, тариалангийн талбайн хөнөөлт организм, мэрэгчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Энхболд томилогдон ажиллаж байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
Байгууллагын хэмжээнд ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн талаарх Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтад хамрагдаж, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл хүргүүлж ажиллав. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, Комиссар Б.Баяртөгсийн зохион байгуулсан сургалтад 2025.10.28-ны өдөр хамрагдсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд ёс зүйн дүрэм, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, Ёс зүйн дэд хорооны хурлыг зохион байгуулж, ирүүлсэн мэдээллийг холбогдох журмын дагуу хэлэлцэн дүгнэлт, зөвлөмж гаргав.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал
Томилох эрх бүхий албан тушаалтан нь төрийн албанд ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлэх, сахилга, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд манлайлал үзүүлж ажиллаж байна. Тухайлбал, ёс зүйн дүрэм, холбогдох хууль тогтоомжийг мөрдүүлэх, албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын 7 хоногийн шуурхай хуралдаан бүрд удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллав.

Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг дэмжиж, хурлын шийдвэр, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч, ёс зүйн зөрчилд хүлцэнгүй хандахгүй байх зарчмыг баримталсан. Мөн шинээр томилогдсон болон удирдах албан тушаалтнуудад ёс зүйн чиглэлээр чиглүүлэг өгч, үлгэр дуурайлал үзүүлэхэд анхаарч ажилласан. Үүний үр дүнд байгууллагын хэмжээнд ёс зүйтэй, ил тод, хариуцлагатай ажлын орчин бүрдэж, албан хаагчдын ёс зүйн ухамсар, хариуцлага дээшилж байна.	
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	
Ёс зүйн дэд хороо нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлэх, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Тайлант хугацаанд Ёс зүйн дэд хорооны хурлыг зохион байгуулж, ирүүлсэн мэдээлэл, зөрчилтэй холбоотой асуудлыг холбогдох журмын дагуу хэлэлцэн, нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, удирдлагад зөвлөмж хүргүүлэв. Мөн зөрчил дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж ажиллав. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны үр дүнд албан хаагчдын ёс зүйн хариуцлага дээшилж, ёс зүйн зөрчилд хандах байгууллагын хяналт, зохион байгуулалт сайжирч байна	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл
Ёс зүйн дэд хороог байгуулж, төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан ажилласан. Байгууллагын албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар сургалтыг бусад төрийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулсан.	Хуулийн мэдлэг дутмаг байдал
Санал: Ёс зүйн дэд хорооны гишүүдэд Ёс зүйн хорооноос сургалтыг цахимаар тогтмол зохион байгуулах, сургалтын цахим материалаар хангах.	

Шалгах хэсэг:

- “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх

БАТАЛГААЖУУЛАЛТ:

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.УЛАМБААТАР

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА:
УРГАМЛЫН ХОРИО ЦЭЭР, ЭКСПОРТ, ИМПОРТЫН
АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.БАТЗОРИГ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:
АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ ХАРИУЦСАН АЖИЛТАН Э.НОМИН-ЭРДЭНЭ